

ТҮҮХ

**МОНГОЛЧУУД ХАРЬ
ОРНУУДТАЙ ХАРИЛЦАХЫГ
СОНИРХСОН НЬ**

(XIX зууны хоёр дахь хагасаас XX зууны эхэн үе)

Академич Б. ШИРЭНДЭВ

Олон зууны турш хөрш Хятад, Орос оронтой тогтоосон улс төр-эдийн засгийн уламжлалт харилцаа ба ламын шашны төв-Төвдтэй шашны холбоотой байсан Монгол оронд XIX зууны хоёрдугаар хагас, XX зууны эхээр нэлээд өөрчлөлтүүд гарав. Өрнөдийн хөрөнгөтөн орнууд ба Япон улс манж Чин улсын цэрэг стратегийн хувьд чухал далайн боомт буудлууд ба төрөл бүрийн нөөцөөр баялаг мужууд руу зэвсэгт хүчнээр түрэмгийлэн орж, эдийн засгийн хувьд ноёрхож эхэлсэн нь феодалын байгуулалт Чин гүрэн, мөн түүний зах хязгаар болсон Гадаад Монголыг дэлхийн капиталын зах зээлрүү татан оруулжээ.

Манж Чин улсын засгийн газар хаант Орос улсын нөлөөг Гадаад Монголд ихэсгэхгүйн тулд юуны өмнө Монгол оронд Хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдийн үйл ажиллагааг хязгаарлаж байснаа өөрчилж, малын бэлчээрийг хомсгон, аль үржил шимтэй газарт хятад тариачдыг олноор оруулан колоничлож байв. Хятадын худалдаачид мөнгө хүүлэгчдийн олон пүүс дэлгүүрүүд Гадаад Монголд өргөн тархав. Энэ бүхэн нь манж, монголын феодалуудын тэсэхүйеэ бэрх дарлалыг хүлээж ирсэн ард түмний зовлонт байдлыг улам хүндрүүлжээ.

XX зууны эхээр монгол орны зах зэл дээр Англи, Америкийн зэрэг өрнөдийн орны пүүсүүд бас буй болж, Хятадын худалдаачдын дэмжлэгээр буюу биеэ даасан үйл ажиллагааг явуулж байв. Чин улсын засгийн газар Гадаад Монгол ба хаант Орос улс хоёрын хооронд тогтсон худалдаа, эдийн засгийн харилцаанд саад хийхийг хичнээн оролдсон боловч эртний энэ харилцаа зогсох байтугай улам ч хөгжсөөр байв. Оросын консулын газар 1860 онд Их хүрээнд дараа нь тус орны зарим төвүүдэд тус тус байгуулагдсанаар хоёр орны хоорондох худалдааны харилцаа улам өргөжсөн билээ. Чухам энэ үеэс эхлэн 1900 он хүртэлх хугацаанд орос монголын худалдааны ерөнхий эргэлт хэдэн арав дахин өсчээ. Ингэж харь гүрний худалдаа Монголын зах зээл дээр идэвхжиж ирсэн нь тус оронд таваар мөнгөний харьцааг хөгжүүлэхэд аяндаа нөлөөлөв. Зарим ван, гүн, чинээлэг лам, ардууд худалдаа арилжаа үүсгэн явуулж тус орны хүн ам ба гадаадын пүүсүүдийн хооронд жуулчилж эхэлсэн билээ.

II

Нутгийн ба манжийн феодалуудад мөлжигдөж байсан монголын ард түмэн хятадын худалдаа, мөнгө хүүлэгчид ба хөрөнгөтөн орны пүүсүүдийн талхидалд давхар нэрвэгдэх болов. Монголын ард түмнээс манж ба өөрийн орны феодалын эсрэг явуулж байсан үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн Оросын 1905 оны хувьсгалын нөлөөгөөр урьд өмнө үзэгдээгүй өргөжиж, зохион байгуулалттай болж байв. «Дэлхийн капитализм ба 1905 оны Оросын хөдөлгөөн Ази тивийг бүрмөсөн сэрээсэн»¹ гэж В. И. Ленин Азийн тэр үеийн байдлаас гүн гүнзгий тодорхойлсон юм.

Ард ангийн тэргүүний хүмүүс ард ба монголын нийгмийн сэхээтний давхаргын дэвшилтэт төлөөлөгчид олон улсын харилцааг ихээхэн сонирхож эхлэв. Үүнд Орос оронд явуулж байсан худалдаа, соёлын харилцаа өргөжиж байсан нь ихээхэн нөлөөлөв. Уг харилцаа алба, амины хүмүүс харилцан солилцох журмаар хэрэгжиж байсны дотор нэг нэгэндээ талархан, сайн хөршийн харилцааг хөгжүүлэх гэсэн хүмүүс цөөнгүй байсныг дурдах нь зүйтэй. Тэдгээр хүмүүсийн тоонд хоёр орны хооронд түүхий эд, бараа таваар тээвэрлэн зөөж байсан жинчид мөн эд бараа солилцон тус тусын орны байдлыг сонирхож байсан хил хязгаарын хүн ард мөн орно. Наад захын нэгэн жишээг дурдвал: Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч ван (одоогийн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг) Орос орны соёлын туршлагыг сонирхон Эрхүү хотын мужаан нарын тусламжаар хошууныхаа төвд хоёр давхар дүнзэн ордон бариулж Европ маягийн заслагаар тохитой чимсэнийг нутгийнхан сайн мэднэ.

Байгаль далайн хавь нутгаар очиж байсан дорнод Монголын лам Пунцаг зэрэг хүмүүс Орос орны байдалтай танилцаад Оросын ард түмний нэр хүндийг монголчуудын дунд дэлгэрүүлж байсан юм гэж Оросын эрдэмтэн Г. И. Потанин² заан тэмдэглэсэн байдаг. Үүний нөгөөтэйгүүр Монгол оронд аливаа нэгэн хэргээр ирж байсан орос хүмүүс монголчууд тай дотно харилцаж, тэдэнд өөрийн орны тухай ярьж байжээ.

Н. П. Пржевальский, П. К. Козлов, В. А. Обручев, В. Л. Комаров нарын зэрэг оросын нэрт эрдэмтэд монголын янз бүрийн давхаргын төлөөлөгчид ялангуяа өөрсдийн замчин ардуудтай байн байн уулзан ярилцаж байсан тэдний хэвлүүлсэн эрдэм шинжилгээний тайлан, замын тэм дэглэлээс тодорхой байдаг.

Монгол хэл бичиг сайн мэддэг байсан монголч эрдэмтэн А. М. Позднеев, Г. Н. Потанин, Б. Я. Владимирцов нар орос орны амьдрал, Европын соёл, дэлхийн үйл явдлыг монголчуудын дунд хуучлан ярьж, тэдний сонирхлыг өрнүүлдэг байсан нь эргэлзээгүй билээ. Монголын эрх чөлөөний хөдөлгөөн 1911-1913 оны Хятадын хөрөнгөтний ардчилсан хувьсгалтай нэгэн үед өрнөж, түүний нөлөөг тусгаж байсан нь багагүй ач холбогдолтой байв.

Тусгаар тогтсон Монгол улс байгуулахыг санаачлагч нар монголын зах зээлийг сонирхож байсан хаант Орос улсын дэмжлэгийг өөрсдийн цаашдын үйл ажиллагаанд авахыг эрхэмлэж байв. Хаант Орос улсын засгийн газар Монгол оронд байр сууриа бэхжүүлэхийг ихэд хүсч байсан боловч Гадаад Монголыг нэгэн адил колоничлох сонирхолтой байсан Япон, Англи, АНУ зэрэг орнуудтай Монголын асуудлаас болж харилцаагаа хурцатгахгүйг хичээсэн болгоомжлох бодлого явуулж байв.

Гадаад Монголын засгийн газар, түүний дээд тушаалын дипломатууд хаант Орос улсын засгийн өндөр тушаалын төлөөний хүмүүстэй Их хүрээ ба Петербург хотноо удаа дараалан хэлэлцээр хийж Дотоод Монголыг багтаасан монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх саналыг ухралтгүй дэвшүүлж байв. Удаан хугацааны энэ хэлэлцээрийн хувь заяага Гадаад Монголд автономит эрх олгох тухай Орос, Хятад хоёр улсын урьдчилсан хэлэлцээр шийдвэрлэсэн юм. Үүний уршгаар Монгол, Хятад, Орос гурван улсын төлөөлөгчдийн бага хурал гэгч зохиогдож Гадаад Монголын талын дээрх хүсэлтийг автономит эрхээр хязгаарласан билээ. Империалист гүрнүүд ба Манж Чин улсын ийм сэм арилжаанаас болж Монголын тусгаар тогтнолыг Японы эзэн хаант улсын засгийн газрын зүгээс дэмжүүлэх ба АНУ, Англи, Герман, Франц, Бельги зэрэг

орнуудтай дипломат харилцаа тогтоохыг эрмэлзсэн монголын дипломатуудын хүсэлт ч мөн нэгэн адил бүтээгүй билээ.

III

Гадаад, дотоод харилцааны хувьд нэлээд өргөн эрхтэй, автономит Монгол орон Орос оронтой худалдаа, эдийн засаг, соёлын харилцаагаа өргөжүүлэх бололцоотой байв. Энэ нь монголын дэвшилт үзэлтэй зарим хүмүүс эдийн засаг ба соёлын талаар хэд хэдэн арга хэмжээ авч явуулахад бодит дөхөм болсон бөгөөд тэр нь улмаар Орос оронд өрнөж байсан хувьсгалт хөдөлгөөний үзэл санааг монголчууд тусган авахад тус хүргэсэн билээ. Нийслэл хүрээн дэх цахилгаан хороо, утасны хороо, хэвлэлийн хороо, Ерөө голын алтны уурхайд ажиллаж байсан зарим монголчууд шинэ үйлдвэрийн техниктэй танилцаж, ардчилсан үзэл бүхий орос хүмүүстэй уулздаг байв. Нийслэл хүрээний сургууль, Хужирбулангийн цэргийн сургууль, Эрхүүгийн сургуульд сурч байсан монгол залуучуудын дотроос нэлээд тооны хүмүүс оросын хувьсгалын үзэл санааг тусган авч байсан нь тодорхой билээ. Нийслэл хүрээнд хэвлэгдэн гарч байсан сонин, сэтгүүл нь төрийн байгууллагыг ардчилах, Европын жишээгээр соёлыг хөгжүүлэх ба Орос оронд болж байсан хувьсгалт үйл ажиллагааны мэдээний талаар чухал зүйлийг хэвлэдэг байжээ. Бүхэлдээ Монголын нийгэмд хуучнаас шинэрүү тэмүүлэх, олон улсын үйл явдлыг сонирхох ба гадаадтай харилцахыг эрмэлзэх явдал идэвхжиж байв.

IV

XX зууны эхээр Ази ба Европын орнуудаар явж, юм үзэх сонирхолтой хүмүүс Монгол оронд нэлээд байв.

Тэд тээврийн аль тохиолдсон хөсгөөр алсын хүнд замыг туулан зовж зүдэрч явахдаа янз бүрийн оронд очоод аль ч газрын хүмүүс баян ба ядуу, эрх дархтай ба дарлагдан зовсон гэж хоёр хэсэгт хуваагдан байсныг үзэж мэдэх бололцоотой байснаас гадна ер бусын сонин олон зүйлийг харж, дэлхийн соёл иргэншил ба ардчилсан үзлийг чадах чинээгээрээ тусган авдаг байв. Тэдгээр хүмүүс эх орноосоо холдон тасраад түүнийгээ санан бодож, эргэж энхрий халамжинд нь орохыг эрхэмлэн хүсдэг байжээ.

Тийм хүмүүсийн нэг бол олон улсын эсперанто хэлийг сурсан анхны монгол хүн Намжилын Хаянхярваа* байв. Н. Хаянхярваа тэр үеийн бараг бүх эрэгтэй хүүхдүүдийн нэгэн адил хүрээнд сургууль хийж байгаад ядуугийн эрхээр өрөнд баригдаж 1900 онд 24 насандаа Орос оронд оджээ. Тэрээр орос нутагт 3 жил байхдаа Халимагийн Буддын нэгэн дацанд сууж боловсролоо дээшлүүлэн халимагчуудтай танилцаж байжээ. Н. Хаянхярваа Орос орны боловсронгуй амьдралтай танилцаж, улмаар даян дэлхийг сонирхох болжээ. Тэр бусдын ажил хийж олсон цөөн мөнгөөрөө Английн хөлөг онгоцонд сууж. Хар далайгаар гатлан Турк улсад очжээ. Хаянхярваа тэгж явсаар урьд өмнө үзээгүй эрс ондоо амьдралд орж,

* Н. Хаянхярваа 1885 онд одоогийн Хэнтий аймгийн Цэнхэр мандал сумын нутагт ядуу шавь ард Намжилын гэрт төржээ. Түүний тухай мэдээ МАХН-ын ТХ-ны дэргэдэх НДС-иас 1974 онд нийтлэн гаргасан «Ууган дээд сургууль» гэдэг товхимлын 58—68-р талд хэвлэгджээ. Улсын хэвлэлийн газар. УБ. Мөн «Урлаг, утга зохиол» сонин 1966—2-р сарын 8-ны дугаарт бий. Дээрх хэвлэлд нийтэлсэн зүйлийн дотор Хаянхярваа чухам хэдэн онд Орос ба Туркээр яваад хэзээ эх орондоо буцаж ирсэн нь зөрөөтэй байдаг.

Турк Европын ядуу хүмүүстэй Стамбул хотноо танилцан далайн боомтын ачаа зөөгчийн түр хугацааны ажилд арай чамай оржээ. Тэр уулзсан хүмүүстэйгээ харилцан ойлголцож чадахгүй байсан бэрхшээлийг даван туулахын тулд Стамбулд эсперанто хэлний курст сурч, уг хэлийг сайн мэддэг болов.

Залуу Хаянхярваа тэнэж хэсүүчилсээр туйлдан ядарч, эх орноо санаж мөрөөдөн явсаар эцэст нь Монгол оронд хувьсгал ялсан тухай мэдээг олж сонсчээ. Тэр ажил хийж арай гэж олсон хэдэн мөнгөөрөө замын зардал хийж Зөвлөлт орос улсын нийслэл Москва хотноо 1922 онд ирж, Монгол Ард Улсын Элчин төлөөлөгчийн газар жижүүрийн үүрэг гүйцэт гэж байжээ. Тэрээр Москва хотноо байх зуураа ЗОУ-ын амьдралтай танилцаж, улмаар Октябрийн хувьсгал ба Зөвлөлт засгийн учир утгыг ойлгон авчээ. Хаянхярваа 1924 онд Улаанбаатарт эргэн ирж, даруй эх орныхоо хувьсгалт үйл ажиллагаанд оролцож МАХН-ын гишүүн болжээ. Тэр сурч мэдсэн боловсрол, эх оронч идэвх зүтгэлийнхээ ачаар МХЗЭ-ийн Төв Хороонд хэлтсийн эрхлэгч, МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын сургуульд захирал, Эрүүлийг хамгаалах яамны сайд, дотоодыг хамгаалах газрын дарга зэрэг тушаалд ажиллаж, ард түмнийхээ тусын тулд хүч хөдөлмөрөө зориулжээ. Тэр алба ажлынхаа хажуугаар эсперанто хэлийг хэсэг монгол залуучуудад зааж байв.

Бас нэг сонирхолтой хүний нэг бол Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны ард Баатарын Данзан байв. Тэр мөн хүрээнд сууж ном үзэж байгаад монгол бичиг сайн сурч, Нийслэл хүрээнд алба хааж, тухайлбал хэвлэх үйлдвэрт ажиллах зуураа Монгол орон зэрэг дорно зүгийн улсуудын түүхийг ихээхэн сонирхох болжээ.

Б. Данзан Хятад улсад хэд хэдэн удаа очиж, Дотоод Монголын залуучуудтай уулзан ярилцаж байв. Данзан 1916 онд худалдааны хэргээр Япон улсад очиж япон хэл сурч, уг хэлээр ярьдаг байсан учир «япон Данзан»³ гэж алдаршжээ. Тэрээр уншсан ном, сонссон зүйл, харсан үнэнийг үндэслэн бодож, шинэчлэлтийн үзэл санаагаа дэвшүүлж байжээ. Б. Данзан Ардын хувьсгалын ялсны дараа Ардын засгийг сайшаан дэмжиж, монгол ардын намд элсэн улмаар Москвад болсон Дорно дахины ард түмний I их хуралд оролцсоны дараа Москва хотод Монголын элчин сайдаар ажиллаж байгаад МАХН-ын Төв Хороонд удирдах тушаалын алба гүйцэтгэж байв.

Зөвлөлтийн нэрт эрдэмтэн, дипломат И. Майский 1918 онд Сайн ноён хан аймгийн нэгэн том хүрээний газар (Заяын хүрээ бололтой) уг хүрээний зурхайн дацны удирдагч Содном лам гэдэгтэй уулзаж ярилцжээ. Тэрхүү Содном Майскийд өөрийнхөө аялсан тухай өгүүлэхдээ: Петербург (энд 2 жил болжээ), Герман (Берлин хотноо Шуцман гэдэг айлын гэрт сууж байхдаа монгол хэл мэддэг нэгэн герман иргэнтэй танилцжээ), Париж, Швейцар, Итали, Турк (Константинопольд байжээ), Энэтхэг, Хятад (Шанхай, Бээжин, Хаалган) зэрэг орнуудаар явсан гэжээ. Содном оросын ард түмэн түүний ахуй байдлын тухай багадаа эцгээсээ соносон гэж Майскийд хэлжээ.

Содном европын соёл иргэншлийн агуулгыг түргэн зуур ойлгож, ардчилсан үзэл санааг соргогоор тусган авч улмаар Хятадын хувьсгалын жилүүдэд Шанхай хотноо Гоминьдан намд элсчээ. Тэрээр аливаа социал демократ намын эрмэлзлэлийн тухай И. Майскийд ярьж байгаад «Тийм нам нь ард түмэн өөрөө өөрийнхөө хэргийг хөтлөх, Богд хаангүй улс бай-

гуулах, ядуу баяны ялгаагүй цөм эрх тэгш байхыг эрмэлздэг»⁴ юм гэж цохон ярьж байжээ.

Тэрхүү жуулчин лам оддыг ажигладаг дуранг мэддэг байсан бөгөөд европын амьдрал, түүний шинжлэх ухааныг ихэд сонирхож, газар дэлхий бөөрөнхий хэлбэртэй тухай онолыг хүлээн зөвшөөрч, англиар яриад бас герман, Франц хэлээр хэд хэдэн өгүүлбэр хэлж байсан гэж Майский тэмдэглэжээ. «Тэр лам бүхэл бүтэн шинэ сэтгэлгээ, шинэ санааг авчирсан хүн байлаа» гэж И. Майский бичжээ.

V

XX зууны эхээр дэлхийн нийгэм-эдийн засгийн амьдралд гарсан шинэ зүйлс нь Монгол ба Төвдийн том хүрээ хийдүүдээр дээр үеэс жуулчилж заншсан мөргөлчдийн амьдралд ч тусгалаа олжээ.

Төв Азийг судлагч эрдэмтдийн бүтээлд бадарчин, мөргөлчин, гуйлгачин нарын тухай цухас дурдсан байдаг. Дээрх гурван нэр хүлээж байсан хүмүүс нь сүсэг бишрэлийн хувьд адил боловч нийгмийн гарал хөрөнгө чинээгээрээ ялгаатай байжээ. Халхаас Цайдамыг дамжин Баруун Зууд хүрдэг замын Шведийн эрдэмтэн Свен Гедин «Их зам» гэж нэрлэсэн байдаг бөгөөд мөргөлчид тэр олон мянган километр замаар хүнд үүрэг үүрч голдуу явган аялдаг байснаас гадна хааяа нэг, хоёр тэмээ буюу луус, сарлаганд номаа ачиж аялдаг. Тэдний ихэнх ядуу лам, харчууд, эмэгтэйчүүд байжээ. Харин дээд тушаалын буюу чинээлэг лам нар нь Төвдөд очихдоо хөсөг хэрэглэж шавь нар буюу албат нараа дагуулан явдаг байснаараа дээр өгүүлсэн ядуу бадарчин мөргөлч нараас эрс ялгаатай байв. Тэд Төвдөд янз бүрийн албан ажлаар явдаг байна. Үүнд: Богд гэгээний удаа дараагийн дүрийг залж ирэх ба халхын тэр энэ хошууг даадаг «Гачин лам» гэдгийг залж ирэхээр явдаг байжээ. Зарим нэг чинээлэг лам нар шашны мэргэжлээ дээшлүүлэх зорилгоор Төвдийн том хийдийн нэртэй дацангуудад удаан хугацаагаар суудаг байв. Тийм лам нарын зарим нь сүүлдээ эрдэмтэй түүхч нар болж байсны жишээ бол Зая-бандид Лувсанпэрэнлэй, Сүмбэ хамба Иши-балжир нарын зэрэг хүмүүсийг дурдаж болно⁵.

Төвдийн Баруун Зуу, Гүмбум, Лавран хийдүүдийн шашны дээд сургуульд удаан хугацаагаар ном үзэж байсан эрдэмт лам Агваанбалдан, Зава Дамдин нар өөрийнхөө бүтээлд лам нарын хуурамч зан суртахуун ба манжийн феодалын харгис шунахай талыг илэн далангүй буруушааж байжээ⁶. Зарим чинээлэг лам нар шашны сургаал, анагаах, буддын философиор мэргэжлээр дээшлүүлж, Монгол орондоо эргэж ирээд том хүрээ хийдэд өндөр хэргэм тушаал эзэлдэг байв. Бас нөгөө хэсэг нь Төвдөд очиж, эргэжлээ дээшлүүлээд тэндээ үлдэж, томхон хүрээ хий динн газар сууж чухал тушаалын үүрэг гүйцэтгэдэг байжээ. 1936 он гэхэд Буддын шашны гүн ухаан, Төвдийн анагаах ухааны талаар эрдмийн зэрэгтэй хэсэг лам нар Төвдийн аливаа нэгэн дацанд өндөр тушаал эзэлж сууж байсны дотор Сэра дацанд Архангай аймгийн Дандар лхаа рамба, Брайбун дацанд Лигдэн хамба, Гомон дацанд лхаарамба Лувсан, түүний шавь нар Санжаа, Сэнгээ нар байжээ. Тэд хангай зүгийн хошуудын хүмүүс байсан ажээ.*

Ядуу лам, харчууд Төвдөд жуулчлан очдог байсан тухай дээр өгүүлсэн билээ. Тийм хүмүүсийн тоонд Улаанбаатар хотын Чингэлтийн хороо-

* Д. Чанаравын ярьсан яриа, түүний тухай цааш өгүүлэх болно.

лолд суудаг Намчин Лувсандорж (Дундговь аймгийн харьяат) 1978 онд Улаанбаатар хотод нас барсан «бадарчин» Лувсанчүлтэм нар байв.* Тэрхүү Лувсанчүлтэм нь одоогийн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн бөгөөд 1910 онд 20 настай байхдаа Төвдөд очиж тэндээсээ Энэтхэг оронд хүрчээ. Тэрээр жуулчлан явсан газар оронд чадах чинээгээрээ хар ажил хийж амьдарч яваад Энэтхэгт сууж байсан Монгол, Төвд, Энэтхэгийн түүх, утга зохиолыг нэвтэрхий судалсан эрдэмтэн Ю. Н. Рерихтэй танилцжээ. Лувсанчүлтэм эрдэмтэн Рерихээс Монгол, Төвд, Энэтхэг, Хятадын түүхийн талаар сонин зүйлийг олонтаа сонссон нь түүнд их тус болжээ. Тэрээр төвд хэлбичгийг судалж, нэлээд зүйл сурчээ. Тэр Энэтхэгээс Улаанбаатарт эргэн ирмэгц төвд Ганжуурыг засаж сэлбэх ажилд оролцжээ. Дашрамд дурдахад уг номын олон ботийг сэлбэх ажлыг Н. Сэрээтэр хийж одоо дуусгаж байгаа болой.

Буддын философийн «Равжамба» зэрэгтэй Д. Шарав, Цэнд, Сундуй, Ням, Лүндэг нар Төвдийн Баруун Зууд мөн л бусдын адил үүрэг хүрч явганаар аялан очицгоожээ. Тэдний нэг Д. Шарав Баруун Зууд олон жил болж Буддын философиин Равжамбын зэргийг хамгаалжээ. Тэрээр эх орноо бусдын нэгэн адил бодолхийлж явсаар замд тохиолдсон олон бэрхшээл-Өвлийн тэсгэм хүйтэн, усгүй цөл говь, Идрэнгийн нурууны өндөр хярыг давж хөдөө нутагтаа 1945 онд эргэн иржээ. Тэгээд Д. Шарав ах дүү, айл садныхаа дунд амьдарч, сурсан дадсан ажлаа хийж, малчин болоод нэгдэлд элсэж, сумын тэргүүний малчны тоонд оржээ.**

Энд нэр дурдсан болон дурдагдаагүй бадарчин нар «Суусан цэцнээс явсан тэнэг дээр» гэгчээр харь газар жуулчлан явж, очсон орон, явсан газрын зан заншил, газарзүй, аж ахуй, соёлыг ажиглан сайн мэддэг болсон хүмүүс байжээ. Монголын аман зохиолд бадарчингуудын хэлсэн цэцэн мэргэн үг, хошин үг олон байдаг. Тэр бүтээлүүдэд хар шар феодалуудыг хурц мэргэнээр шүүмжилсэн байдаг⁷.

Энэ сэдвээр сонирхолтой хүний нэг бол эдүгээ эсэн мэнд амьдран сууж буй угийн ард гаралтай Дамбын Чанарав юм. Д. Чанарав 16 насандаа авга ахаа дагаж алсын аянд хөдлөн эхлээд Өвөр Монголын зарим хошуу, Хөх хот, Жанчхүү, Бээжинд очжээ. Тэр Хятадын дээр дурдсан хотуудаас буцаж, Өвөр монголын хошуунд ирээд дуганы барилга дээр мужааны ажил хийж байгаад Алшаа хошуунд очиж мөн 3 жил мэргэжсэн ажлаа хийжээ.*** Чанарав энд өөрийн нутгийн бүсгүй Хандтай ханилан сууж жуулчлалаа үргэлжлүүлэхээр шийджээ. Тэр хоёр зарим газар явган, хааяа тэмээ буюу луусаар аялан явсаар «Дээд Монгол»-ын нутагт иржээ. Тэндээсээ тэд зарим газар явган, заримдаа сарлаг унаж, 12 өдрийн замыг туулан Гүмбум хийдэд иржээ. Тэд Гүмбумаас 4 сар жуулчлан явсаар Баруун Зууд хүрчээ. Чанарав, Ханд нар Төвдөд хэдэн жил болоод Балбын Катманду, Лумбин хоёр хотоор ороод Гималайн өндөр уулыг

* Энэ хоёр хүний тухай товч тэмдэглэл надад буй.

** Д. Шаравын тухай мэдээг түүний хүү, МУИС-ийн монгол хэлний багш Чоймаагаас олж авсан. Д. Шарав (1889—1971 он) одоогийн Говь-Алтай аймгийн Төгрөг суманд ядуу ардын гэр бүлд төржээ. Д. Шарав цагийн эрхшээлээр Усан зүйлийн хүрээнд сурч байгаад Гандан хийдэд шилжин суужээ. Тэр төвдийн Баруун Зууд очиж суралцаад, Буддын философийн «Равжамба»-ын зэргийг хамгаалж, өндөр үнэлэлт авч, сайшаалын үнэмлэхээр шаг нүүлжээ.

*** Д. Чанаравтай хийсэн ярианы тэмдэглэл, Д. Чанарав 1914 онд Сайн ноён хан аймгийн Балдан засгийн хошуунд төржээ. (Одоогийн Өмнөговь аймгийн Ноён сум)

давж Энэтхэгт хүрчээ. Чанарав ингэж явахдаа мужааны ажил хийж авгай нь үйл оёж, өлөн зэлмэн амьдардаг байжээ. Тэд 4 хүүхдээ Энэтхэгийн сургуульд оруулж, энэтхэг, англи хэл сургажээ. Чанарав өөрөө төвд энэтхэг ярианы хэл мэднэ.

Чанарав явсан газар орны байгаль, цаг уур, зан суртахуун, соёл, ард түмний амьдралын талаар сонирхолтой сайхан яриаг бидний хүсэлтээр ярьж өгсөн билээ. Чанаравынхан харь газар сууж байхдаа хайрт эх орондоо эргэн ирэхийг ямагт хүсэн мөрөөдөж байжээ. Тэдний удаан хүлээсэн баярт өдөр 1971 онд тохиолдож, эх орондоо буцаж ирэв. Бид эх орондоо ирээд энх түвшин, аз жаргал дүүрэн амьдарч байна гэж Д. Чанарав зүрх сэтгэлээ хөдөлгөн ярьж байдаг. Түүний хүүхдүүд Улаанбаатарт их, дээд сургууль дүүргэж эцэг, эх, хүүхдүүд цөм ажилтай, тохилог сайхан орон сууцанд амьдардаг ажээ.

«Таны явсан газар оронд одоо монгол бадарчин олон байна уу?» гэж намайг асуухад, Чанарав: «Одоо шинээр очсон бадарчин байхгүй, харин урьд явж байсан бадарчдаас 1930 он гэхэд Баруун Зууд монгол хүн 70 байсан. Тэд монголын хороолол, «Соггу Мяцан» буюу эс бөгөөс халхын хороолол «Самал Хамран»-д суудаг, Балбад 8, Энэтхэг 10-аад хүн байсан» гэж хариулсан юм.

Тэгж жуулчилж явсан бадарчин, мөргөлчин нар сүсэг бишрэлийн эрхээр «диваажин»-гийн амьдралыг эрэн яваад түүнийгээ хаанаас ч олж чадсангүй буцаж ирцгээсэн ажээ. Харин тусгаар тогтносон эх орондоо эргэж ирсэн цөөн хэсэг нь жинхэнэ аз жаргалаа олцгоожээ.

Империалист гүрнүүд газар дэлхийг хуваасан ба 1905 оны Оросын хувьсгал гадаад ертөнцөөс тусгаарлагдмал өндөр уулсын Төвд оронд нэгэн адил нөлөөлснийг тэмдэглүүштэй.

Английн түрэмгий цэргийн анги 1904 онд Баруун Зууг эзэлж сүйдэлсэн ба Орос оронд гарсан хувьсгалт үйл явдал нь Төвдийн ард түмнийг хамгийн наад захын эрх чөлөөнийхөө төлөө тэмцэхэд нөлөөлжээ. Төвдийн шашны тэргүүн XIII Далай лам Түвдэнжамц Английн булаан эзлэгч нараас зугатан гарч гадаад Монголд нууцаар ирсэн билээ. Тэр Халхын нөлөө бүхий ноёдтой уулзан хоёр орныг манжийн дарлал, харийн колоничлолоос чөлөөлөхийн төлөө явуулах үйл ажиллагааны асуудлыг ярилцан хэлэлцжээ. Гэвч тэдний тэр сайхан хүсэл санаа нь цагийн эрхшээлээр үл биелэгдсэн нь мэдээж.

Аугаа их Октябрийн хувьсгалын хувьсгалжуулагч нөлөөгөөр 1921 онд Монгол оронд мандсан Ардын хувьсгалын ачаар монголын ард түмэн гадаад дотоодын харгисуудын дарлалаас эгнэгт чөлөөлөгдөж тусгаар тогтносон улсаа байгуулсан билээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс төрийн тусгаар тогтнолохоо 67 жилийн дотор Октябрийн эх орон ЗХУ ба ах дүү сотиалист орнуудын тусламжаар улс төр, нийгмийн байгуулал, эдийн засаг, соёлын бүх салбарт асар их амжилт олжээ. БНМАУ өөрийн энх тайванч гадаад бодлогоороо олон улсын зүгээс зүй ёсны хүндэтгэлийг хүлээсэн юм. Эдүгээ манай орон 100 гаруй оронтой дипломат, 30-аад оронтой худалдааны харилцаатай байна. БНМАУ одоо НҮБ ба ЭЗХТЗ-ийн гишүүн бөгөөд олон улсын 70 гаруй байгууллагын үйл ажиллагаанд оролцож байна. БНМАУ нь ЗХУ ба социалист орнуудын хамт манай гаригийг цөмийн зэвсэггүй

болгож, бүх нийтийн аюулгүй байдал, тэгш эрх, зэвсэг хураах, бүх улсуудын хооронд энх тайван, хамтын ажиллагааг хангахын төлөө идэвхтэй тэмцэж байна.

1. Ленин В. И. Пробуждение Азии. -Зохиолууд, 19-р боть. х. 66
2. Потанин Г. И. Путешествие по Монголии. Изд-во географической литературы, 1948 с. 358
3. Ширендыб Б. Монголия на рубеже XIX-XX вв. УБ, 1963 с. 145
4. Майский И. М. Монголия накануне революции. Изд-во Восточной литературы. М. 1959 с. 269-274
5. «БНМАУ-ын түүх» Нэгэн боть, нэмэн засварласан 3 дахь удаагийн хэвлэл, УХГ УБ, 1984
6. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. УХГ, УБ, 1978
7. Монгол ардын шог хошин үлгэр. УХГ, УБ, 1984 х. 190—198

МОНГОЛЫН 1911 ОНЫ ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДАГЧ

Л. ЖАМСРАН

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Монголчууд Чин улсын ноёрхолыг бүр анхнаас нь эхлэн эсэргүүцсээр ирсэн нь XIX зууны сүүлчээс нэн идэвхжиж XX зууны эхний арван жилд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн болон төлөвшсөн юм. Түүний өрнөлтийн дээд туйл нь 1911 он байсан тул 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэж товчоор нэрлэж байна.

Чин улсаас салж Монголын төрийн тусгаар тогтнолыг сэргээх хэргийг санаачилж, удирдан зохион байгуулагч нь хэн байсныг Монголын түүх судлал тусгайлан судлаж нэгэн мөр болгоогүй байгаагаас XX зууны эхний Монголын түүхээр гарсан бүтээлүүдэд янз янзаар бичсэн байдаг. Тэдгээрийг өрөнхийд нь хоёр ангилж болно. Үүнд: 1. Монголд 1911 онд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөсөн. Түүнийг Жибзундамба хутагт тэргүүтэй Монгол феодалууд удирдсан, хөдөлгөгч хүч нь Монголын ард түмэн байсан. 2. XIX зууны эцэс XX зууны эхээр Монголчууд үндэснийхээ эрх чөлөөний төлөө босч тэмцээгүй, зөвхөн хаант Орос улсын хатгалгаар Жибзундамба хутагт тэргүүтэй цөөн феодал урваж, тусгаарласан гэж Чин улсын ноёрхолыг зөвтгөж Монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг үгүйсгэж, түүх гуйвуулсан байдаг.

Энэ хоёр үзлийн адил тал нь Жибзундамба хутагтыг 1911 онд Монголд болсон хэрэг явдлын удирдагч гэж үзэж байгаа явдал мөн. Гэтэл Жибзундамба хутагт бол Чин улсын төрөөс Монголчуудыг шарын шашны суртлаар мунхруулан барьж байх үүрэг хүлээсэн, тавиулын этгээд, харийн хүн билээ. Тус улсын түүхийн Төв Архив дахь баримт хэрэглэгдэхүүнийг үзэхэд, Жибзундамба хутагт Монголын үндэсний тусгаар тогтнолыг сэргээх явдлыг анх санаачлан, түүний төлөө тэмцэгч, олон нийтийг зохион байгуулагч биш байжээ. Харин тэр хэргийг жинхэнэ санаачлан зохион